



ДУНДГОВЬ АЙМАГ  
ЭРДЭНЭДАЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 20 өдөр

Дугаар A/48

Сангийндалай


Хязгаарлалтын дэглэм цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэр, нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Цагаан-Овоо багийн Өвөр хад нутаг дэвсгэрт N105.181147, E45.7154765 солбицол бүхий газруудад бог малын гоц халдварт мянган өвчний сэжигтэй тохиолдол илэрч 2023 оны 03 дугаар 03-ны өдрөөс 20-ны өдрийг дуустал 17 хоногийн хугацаатай тогтоосон хязгаарлалтын дэглэмийг цуцалсугай.
2. Малыг эрүүл мэндийн үзлэг, тандалтад хамруулж ажиллахыг багийн Засаг дарга нарт, малын шилжилт хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг сумын Мал эмнэлгийн Тархвар зүйч (Т.Машбат)-д үүрэг болгосугай.
3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ард иргэд, малчдыг мянган өвчинөөс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллээр хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (О.Базаррагчаа), Хөдөө аж ахуйн тасагт үүрэг болгосугай.
4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн A/40 тоот захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ

О.БАЗАРРАГЧАА



482302095